



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/02

Хатан суудал

**Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн
тоо бүртгэлийг зохион байгуулах тухай**

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Цаг уур, орчны шинжилгээний газрын 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 01/723 тоот албан бичиг зэргийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 01 дүгээр сарын 06-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл явуулах ажлын хэсгийг доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Энхбат-Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Л.Энхбаатар- БОАХМ

Гишүүд:

Цэвэлмаа- Цаг уурын ажилтан

Ц.Намхайхорол-2 дугаар багийн Засаг дарга

С.Баттулга – 4 дүгээр багийн Засаг дарга

Б.Амаржаргал-5 дугаар багийн Засаг дарга

А.Гантулга-Байгаль хамгаалагч

А.Элдэв-Очир-Тархвар зүйч

Б.Содномдаржаа-Газрын даамал

П.Норовсамбуу-Нярав

3. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн хяналтын нэгдсэн тооллогыг хугацаанд явуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ж.Энхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

О.МӨНХБАТ



642101307